



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагааг
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан гурван иргэн, аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Билэгт Учрал ХХК-ийн "Билэгт Учрал" зочид буудлын 13/213 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 04 сарын 26 өдрийн
А/46... тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.04.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Кондитер Улаанбаатар ХХК	Шинэ Алтай	Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 28
2	Корпорейт Хотел энд Ресорт Нүхт ХХК	Нүхт Ресорт	Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Нүхтийн ам 99
3	Корпорейт Хотел энд Конвейшн Центр ХХК	Корпорейт Хотел энд Конвейшн Центр	Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж 39

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 04 сарын 26 өдрийн
А/46 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2016.04.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Сэлбэ Плаза ХХК	Юби сити	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, То Вангийн гудамж
2	Ариг Эрдэнэ ХХК	Холидэй	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Доржийн гудамж 20
3	Ансен ХХК	Ану Үжин	Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 04 сарын 26 өдрийн
А/46 тоот тушаалын гуравдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.04.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Билэгт Учрал ХХК	Билэгт Учрал	Сонгинохайрхан дүүрэг, 2-р хороо, Орбитийн 21/368

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 04 сарын 26 өдрийн
А/У/16 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.04.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Алтан долгио ХХК	Гүн Молор	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Токиогинь гудамж 30/1
2	Иргэн Х.Мөнхжаргал	Тэгш	Сонгинохайрхан дүүрэг, 11-р хороо, 1-13 тоот
3	Иргэн Х.Нямсүрэн	Маргад	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Шаравын гудамж 31 а

-ooOoo-